## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>110,954,865.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>106,894,865.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>106,721,245.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,626,085.00</b>
210402	Тээвэр, шатахуун	14,626,085.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>720,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0
210702	Дотоод албан томилолт	720,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,994,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,994,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>83,381,160.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,381,160.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>173,620.40</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>173,620.40</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	173,620.40
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,060,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,060,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,060,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>110,954,865.40</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>110,954,865.40</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,060,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	106,894,865.40

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянтэс сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 73 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 95 хувьтай байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Баянтэс сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжтой холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийг шинээр батлан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгж байгуулаагүй, засаг дарга төсөв зарцуулалтад тавих хяналтаа хангалттай хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтэс сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 407,543.4 мянган төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	113,355.0	108,264.3	(5,090.7)
Авлага	93,210.6	159,314.6	66,104.0
Бараа материал	7,289.1	12,883.7	5,594.6
Үндсэн хөрөнгө	868,374.5	1,209,310.0	340,935.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,082,229.2</b>	<b>1,489,772.6</b>	<b>407,543.4</b>
Өр төлбөр	10,081.5	166.9	(9,914.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,072,147.7	1,489,605.7	417,458.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,082,229.2</b>	<b>1,489,772.6</b>	<b>407,543.4</b>

Эх сурвалж: Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 108,264.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,090.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	113,355.00	108,264.30	(5,090.70)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
<b>Дүн</b>	<b>113,355.00</b>	<b>108,264.30</b>	<b>(5,090.70)</b>

Эх сурвалж: Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 5,090.7 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны давсан орлогоос сумын Орон нутгийн хөгжлийн сан болон Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд төсөв нэмж зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 159,314.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 66,104.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	93,210.60	159,314.60	66,104.00
<b>Дүн</b>	<b>93,210.60</b>	<b>159,314.60</b>	<b>66,104.00</b>

Эх сурвалж: Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Авлага данс өмнөх оны үлдэгдлээс 66,104.0 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоог хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 12,883.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,594.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Хангамжийн материал</b>	<b>7,289.10</b>	<b>12,883.70</b>	<b>5,594.60</b>
Бичиг хэргийн материал	161.80	261.80	100.00
Аж ахуйн материал	7,127.30	8,962.30	1,835.00
Сэлбэг хэрэгсэл	-	3,659.60	3,659.60
Түлш, шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал	-	-	-
Бусад хангамжийн материал	-	-	-
Мал амьтад	-	-	-
<b>Дүн</b>	<b>7,289.10</b>	<b>12,883.70</b>	<b>5,594.60</b>

Эх сурвалж: Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 5,594.6 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 5,235.0 мянган төгрөгийн бараа материалыг аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл дансанд тусгасан, тайлант онд 86,074.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 85,714.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материал данстай холбоотой ЗДТГ-т гарсан алдаа, зөрчил байна. Үүнд:

1. Малын тэжээлийг бараа материалын тайланд орлого аваагүй, шууд зардлаар тайлагнасан 22,384.2 мянган төгрөгийн алдааг залруулсан,
2. Малчдад хөнгөлөлттэй олгосон өвс, тэжээл борлуулсны орлогыг хувь хүний дансанд төвлөрүүлж, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, зарцуулалтын тайлан тооцоо хийж хяналт тавьдаггүй, аудитын явцад нотлох баримтыг ирүүлээгүй,
3. Жолоочийн замын хуудасны бичилт дутуу, нягтлан бодогчтой тооцоо нийлдээгүй, шатахуун зарцуулалтын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 2,135.2 мянган төгрөг,
4. Сэлбэг хэрэгсэл, модны суулгац худалдан авсан анхан шатны баримтгүй, данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар тайлагнасан 3,540.0 мянган төгрөгийн зөрчил тус бүрт зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,209,310.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 340,935.5 мянган төгрөгөөр өссөн байна.

## Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>834,716.5</b>	<b>1,171,722.0</b>	<b>337,005.5</b>
Барилга, байгууламж, орон сууц	458,241.8	439,070.4	(19,171.4)
Авто-тээврийн хэрэгсэл	255,390.3	342,679.2	87,288.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	59,327.2	172,839.5	113,512.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	28,802.0	24,599.7	(4,202.3)
Бусад үндсэн хөрөнгө	32,493.3	192,071.3	159,578.0
Ном	461.9	461.9	-
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>33,658.0</b>	<b>37,588.0</b>	<b>3,930.0</b>
Программ хангамж	2,460.0	6,390.0	3,930.0
Бусад биет бус хөрөнгө	31,198.0	31,198.0	-
<b>Дүн</b>	<b>868,374.5</b>	<b>1,209,310.0</b>	<b>340,935.5</b>

Эх сурвалж: Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 340,935.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,060.0 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авсан, 275,603.8 мянган төгрөгийн сумын ОНХС-ийн хөрөнгүүд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 123,300.0 мянган төгрөгийн автомашин, 32,420.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг тус тус данс бүртгэлд тусгасан, 3,465.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, тайлант оны элэгдлийн зардалд 94,363.1 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данстай холбоотой ЗДТГ-т гарсан алдааг залруулсан байна. Үүнд:

1. Худалдан авсан 32,420.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар бүртгэсэн.
2. Хандиваар ирсэн 123,300.0 мянган төгрөгийн автомашиныг данс бүртгэлд тусгаагүй.

## 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 166.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 9,914.6 мянган төгрөгөөр буурсан байна.

## Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,730.80	166.90	(4,563.90)
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	5,350.70	-	(5,350.70)
<b>Дүн</b>	<b>10,081.50</b>	<b>166.90</b>	<b>(9,914.60)</b>

Эх сурвалж: Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Өглөг дансны эцсийн үлдэгдэл 9,914.6 мянган төгрөг болж буурсан нь өмнөх оны байгууллагад төлөх болон бараа үйлчилгээний өглөгийг барагдуулсан байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөр данстай холбоотой ЗДТГ-т гарсан алдааг залруулсан байна. Үүнд:

1. Тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй /бодит бус/ 10,015.8 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгасан.

## 3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,489,605.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 417,458.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	395,149.0	395,149.0	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>650,052.4</b>	<b>1,067,510.4</b>	<b>417,458.0</b>
Өмнөх үеийн үр дүн	5,252,901.5	650,052.4	(4,602,849.1)
Тайлант үеийн үр дүн	(4,602,849.1)	417,458.0	5,020,307.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,946.3	26,946.3	-
<b>Дүн</b>	<b>1,072,147.7</b>	<b>1,489,605.7</b>	<b>417,458.0</b>

Эх сурвалж: Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

ТТЗ нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагч нар тус тусдаа төсвийн төслийг боловсруулан ТЕЗ-ийн холбогдох хэлтэст нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 4 дүгээр тогтоолоор ТТЗ-ийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,251,475.3 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 803,717.1 мянган төгрөг байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 199,078.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 335,752.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 7,808.0 мянган төгрөгийг 2022 оны үлдэгдлээс, 347,817.0 мянган төгрөгийн Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс, 240,872.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 20,000.0 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 100,147.2 мянган төгрөгийг ХХСангийн эх үүсвэр 2022 оны үлдэгдлээс тус тус бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 103,126.9 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 85,135.7 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс Улсын төсөвт байгууллагуудад олгох тогтмол зардлыг 7,926.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Аудитын илрүүлэлт: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт 93,991.6 мянган төгрөгөөр, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтэд 7,926.2 мянган төгрөгөөр тус тус тодотгол хийгээгүй байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 363,992.8 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 420,888.6 мянган төгрөгийн, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 355,743.2 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 41,154.1 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 151,208.0 мянган

төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 152,686.9 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон болон Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нөлөөлж байна.

Хүснэгт 8. Төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	467,119.7	363,992.8	(103,126.9)
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	420,888.6	420,888.6	-
3	Татварын болон татварын бус орлого	156,078.4	43,154.1	(112,924.3)
4	Урьд оны үлдэгдэл	151,208.0	151,208.0	-
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	55,438.1	55,438.1
6	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	347,817.0	355,743.2	7,926.2
<b>ДҮН</b>		<b>1,543,111.7</b>	<b>1,390,424.8</b>	<b>(152,686.9)</b>

Татварын болон татварын бус орлогоор 251,859.2 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 25,737.5 мянган төгрөгийг, санхүүжилтэд 226,121.7 мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,446,400.9 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, ИТХ, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	93,152.1	82,675.1	10,477.0	88.8
2	Засаг даргын Тамгын газар	474,927.8	458,870.0	16,057.8	96.6
3	Орон нутгийн хөгжлийн сан	499,288.6	437,549.4	61,739.2	87.6
4	Хоршоог хөгжүүлэх сан	120,000.0	118,175.0	1,825.0	98.5
5	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	355,743.2	349,131.4	6,611.8	98.1
<b>ДҮН</b>		<b>1,543,111.7</b>	<b>1,446,400.9</b>	<b>96,710.8</b>	<b>93.7</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2023 онд нэмэлт санхүүжилтээр 110,954.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 106,721.2 мянган төгрөгийг тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад, хөрөнгийн зардал зэрэгт зарцуулж, 173.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянтэс сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянтэс сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 3/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2,505,150.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 37,577.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28,182.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төлөвлөгөө гаргаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна. Төсөвт бодит хэмнэлт үүсэн зардал байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 18 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**Аудитын илрүүлэлт:** Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илрээгүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баянтэс сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>					

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 101,917.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 101,917.8 мянган төгрөгийн зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Төсөв баталсан болон тодотгосон тогтоолыг Төсвийн шууд захирагчдад олгосон санхүүжилттэй тулгахад дээд шатны төсвийн захирагчаас тодотгосон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт 93,991.6 мянган төгрөгөөр, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтэд 7,926.2 мянган төгрөгөөр тус тус тодотгол хийгээгүй зарцуулсан зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д "Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ", 34.2.1-д "дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дээд шатны төсвийн захирагчаас тодотгосон төсвийг сумын ИТХ-аар нэмж тодотгож байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт 93,991.6 мянган төгрөгөөр, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтэд 7,926.2 мянган төгрөгөөр тус тус тодотгол хийгээгүй	1	101,917.8					1	101,917.8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>101,917.8</b>					<b>1</b>	<b>101,917.8</b>				

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ

Огноо: 2024-03-14